

Ганбаатарын Галдан<sup>1,✉</sup> Нацагийн Батболд<sup>1</sup>  
Амарбаатарын Болортунгалаг<sup>2</sup>

<sup>1</sup>Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,  
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,

Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

<sup>2</sup>Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей,  
Сүхбаатар, Баруун-Урт, 2-р баг, Уртын гол,

### Бударын чулууны хадны зосон зургийн шинэ дурсгал ба Дорнод монголын нутгаас илэрсэн чулуун байгууламжийн тухай

**Товчлол.** Энэхүү өгүүлэлд Сүхбаатар аймгийн Онгон сумын Бударын чулуунаас шинээр илрүүлсэн зосон зургийн дурсгалыг шинжлэх ухааны эргэлтэд оруулах, тус бүс нутагт 2020-2021 онд хийсэн археологийн хайгуулын явцад олон тоотой бүртгэгдсэн чулуун байгууламжийн тухай өгүүллээ. Бид тус бүс нутгийн хүрлийн эрт үед холбогдох Улаанзуух хэлбэрийн чулуун байгууламж 29, мөн Дөрвөлжин булш 15-ыг бүртгэснээс гадна энэ 2 төрлийн дурсгалтай цогцолбор болон орших чулуун байгууламж 123-ыг илрүүлэн баримтжуулсан. Чулуун байгууламжууд ихэвчлэн Дөрвөлжин булштай хамт, нэг тохиолдолд Дөрвөлжин булш, хадны зосон зургийн хамт нэг дор цогцолбор болон оршиж байна. Бударын чулууны хадны зураг нь шувуу, дөрвөлжин болон дугуй хүрээ байхгүй боловч зургийн зохиомжид олон тооны богиновтор босоо зураасан цэгүүд, адуу, хүн, зам мэт босоо зураас, морь хөтөлсөн хүн байгаа зэргээрээ “Сэлэнгийн” хэмээх хадны зурагтай ижилсэх ажээ. Энэ өгүүлэлд тэгш өнцөгт хэлбэрийн чулуун байгууламж (“Хараат” хэлбэрийн) нь хадны зосон зурагтай хэрхэн холбогдох, улмаар тухайн дурсгалын он цаг, нэршил, зориулалтын тухай таамгийг дэвшүүллээ.

**Түлхүүр үг.** Бударын чулуу, зосон зураг, чулуун байгууламж, оршуулгын зан үйл.

Galdan Ganbaatar<sup>1,✉</sup> Natsag Batbold<sup>1</sup>  
Bolortungalag Amarbaatar<sup>2</sup>

<sup>1</sup>Institute of Archaeology,

Mongolian Academy of Sciences Building-1.

Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

<sup>2</sup>Museum of Ethnology Sukhbaatar Province,

Bag 2, Baruun-Urt town, Sukhbaatar Province, Mongolia

## A new site of red ochre rock art was discovered from Budar chuluu site and new type stone features were recorded in eastern Mongolia

**Abstract.** This article discusses the scientific circulation of the newly discovered ochre painting memorial from the Budar Chuluu site of Ongon soum, Sukhbaatar province, and the numerous monuments recorded during the archaeological exploration in the region in 2020-2021. We have recorded 29 monuments of Ulaanzuukh type and 15 Durvuljin graves related to the earliest period of the region and also discovered and recorded 123 monuments with these two types (Ulaanzuukh type monuments and Durvuljin graves) of monument complexes. This new type of monument often coexists with the Ulaanzuukh grave, and in one case with Durvuljin graves and rock art (red ochre paintings) as a complex. The Budaryn Chuluu site ochre paintings do not have birds and square or round frames, but the composition of the painting contains many short vertical dashed dots, vertical lines such as horses, people, roads, and a man leading horse images are similar types of painting “Selenge”. In this article, we will hypothesize how the rectangular-shaped (“Kharaat” type monument) monument relates to the Ohre painting, then discuss the new monument type’s date, name, and purpose.

**Keywords.** *Budaryn Chuluu, Ohre painting, monument, mortuary practice*

### Удиртгал

Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт Монгол Улсын болон БНХАУ-ын хил дээр орших байгалийн өвөрмөц сонин тогтоцтой боржин чулуун цохиодыг Бударын чулуу гэх бөгөөд нутгийнхан “Догшин Бударын чулуу” хэмээн нэрлэдэг. Эдгээр цохиод тал нутгийн дунд сэрийлдэн алсаас их л сүр бараагай харагдах бөгөөд түүх соёлын эртний дурсгалуудыг хадгалан оршино. Бударын чулууны хадны зургийн дурсгалыг анх 1996 онд Монгол, Солонгосын хамтарсан “Дорнод Монгол” төслийн хээрийн шинжилгээний анги илрүүлэн судалж НТӨ II-I мянган жилд хамааруулан үзсэн байна [Цогтбаатар, Гэрэлбадрах 1997: 66-72]. Тус хээрийн шинжилгээний ангийнхан зөвхөн Бударын чулууны хадны зургийг судалгааны эргэлтэд оруулж бусад дурсгалын талаар дурдаагүй байдаг.

Археологийн хүрээлэнгийн хүрэл, төмрийн судалгааны салбарын 2019-2022 оны хооронд хэрэгжүүлсэн “Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе) сэдэвт ажлын хүрээнд бид Монголын өмнөд, зүүн, зүүн урд бүсийн хадны зураг дахь чулуун зэвсгийн сүүл, хүрлийн түрүү үед холбогдож болох зураг бүхий дурсгалт газруудын байршлыг тогтоож баримтжуулахад голлон анхаарч ажилласан. Судалгааны ажлын явцад Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газар болон Угсаатны зүйн музейн хамтарсан судалгааны баг 2020 оны хавар Бударын чулуунаас шинээр хадны зосон зураг илрүүлсэн мэдээг шалган баримтжуулалт хийхийн зэрэгцээ Бударын чулууны дурсгалт газар хайгуул судалгаа хийж хадны зураг, булш, чулуун байгууламж зэрэг дурсгалуудыг бүртгэн баримтжуулсан билээ [Батболд, Галдан 2020; 2021].

Энэ өгүүлэлд Дорнод Монголын нутагт сүүлийн жилүүдэд хийсэн судалгаагаар хэд хэдэн газар илэрч тэмдэглэгдээд байгаа чулуун байгууламжит дурсгалаас Бударын чулууны дурсгалыг онцлохын зэрэгцээ Бударын чулуун дахь хамгийн их дүрслэлтэй буюу бидний дэвшүүлэн буй саналтай уялдах нэгэн хадны зосон зургийн дурсгалын мэдээллийг багтаалаа.

### Судалгааны арга зүй

Бударын чулуу хэмээх боржин хадтай, гадаргын задгай ус багатай, ургамлын тачир бүрхүүлтэй байгалийн энэ өвөрмөц тогтоцтой газар өмнө нь археологийн нарийвчилсан [Амартүвшин 2004] хайгуул судалгаа хийгдэж байсан Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул [Амартүвшин нар 2015; 2018; Wright et al 2019], Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ширийн чулуу [Бөхчулуун нар 2020] зэрэг дурсгалт газрын геоморфологийн бүтэцтэй ижил байсан. Иймд манай судалгааны баг дээрх дурсгалт газруудад хийсэн хайгуулын арга зүй, мэдээллийн санд тулгуурлан нийт 6 газрыг агаарын зураг ашиглан сонгож гүймэг хялбаршуулсан хайгуулын арга зүйгээр [Амартүвшин 2004] судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Энд бидний судалгааны төсөл болон зорилгын хүрээнд хадны зургийн дурсгал байж болохуйц газруудыг сонгосноо цохон дурдах нь зүйтэй болов уу. Сонгосон талбайдаа ямар нэгэн газрыг үлдээлгүй хамруулахыг хичээж автомашин явах боломжтой газруудаар явж, мөн боломжгүй газруудаар явганаар археологийн дурсгалыг бүртгэж баримтжуулалтыг хийсэн болно. Мөн судалгаа үргэлжлэх хугацаа бага, судлаачдын бүрэлдэхүүн цөөн байсан нь энэхүү

хайгуулын арга зүйг сонгон ашиглах бас нэгэн шалтгаан болсон билээ.

Хадны зургийн баримжуулалтад 2 төрлийн арга зүй хэрэглэсэн бөгөөд нэгдүгээрт, хуучны уламжлалт арга буюу нэвт гэрэлтэж харагддаг гялгар материал дээр 1 x 1 хэмжээтэйгээр хээрийн нөхцөлд хуулга хийх, хоёрдугаарт, тодорхой хэмжээс ашиглан гэрэл зураг авч гэрэл зураг боловсруулах ADOBE өргөтгөлтэй програм дээр хуулга хийх арга зүйг ашигласан болно [Галдан 2010].

#### Хайгуул судалгааны үр дүн.

Бударын чулууны дурсгалт газар хийх хайгуулын төлөвлөгөөний дагуу зосон зургийн дурсгалын мэдээг шалгаж баримтжуулснаас гадна агаарын зураг ашиглан сонгосон 6 газрын эргэн тойрны орчны бүсийг хамарсан нийт 14 км<sup>2</sup> талбайд хайгуул хийсэн. Хайгуул судалгааны үр дүнд тус дурсгалт газраас зосон зураг 3, сийлмэл зураг 8, Дөрвөлжин булш 15, Тэвшийн соёлд хамаарах [Kovalev, Erdenebaatar 2009; Honeychurch 2015; Rawson et al 2020; Галдан, Дайсүкэ 2023] Улаанзуух хэлбэрийн чулуун байгууламж 29, XIII-XIV зуунд хамаарч болзошгүй дугуй хэлбэртэй булш 12, дөрвөлжин хэлбэрийн чулуун байгууламж 123, бусад чулуун байгууламж (цагариг хэлбэртэй, хороо хашаа маягийн гэх мэт) 23-ыг тус тус илрүүлэн бүртгэсэн (Хүснэгт 1). Мөн таамаг сонголтоор хийсэн 6 газраас Неолитын үеийн чулуун зэвсэг бүхий газар 3, мөн ваарны хагархай бүхий газар 5, үүний 3 нь дэргэдээ чулуун

байгууламжтай, 1 нь хадны сийлмэл зургийн дурсгалын хамт, 1 нь чулуун зэвсгийн хамт холилдон олдсон болно. Бүртгэн баримтжуулсан дурсгалуудаас хамгийн их нь тухайн сонгосон 6 газрын ойр орчимд болон цэгээс цэгийн хооронд аялахад таарсан дурсгалууд буюу хүрэл зэвсгийн түрүү (бүс нутгийн хувьд) үеийн (НТӨ 1500-1100 [Wright et al 2019; Taylor et al 2019] булш, оршуулгын байгууламжтай цогцолбор болон орших чулуун байгууламжууд (Зураг 1) юм.

Бидний агаарын зураг ашиглан сонгосон цэгийн 5/6-д буюу бараг 90 хувьд нь дурсгал илэрсэн болно. Энэхүү өгүүлэлд Бударын чулуунаас олон тоотой илэрсэн чулуун байгууламж болон түүнтэй холбогдож болох хадны зосон зургийн талаар тусгайлан авч үзнэ.

#### Чулуун байгууламж.

Бид Бударын чулуунд дээр дурдсанаар тус бүс нутгийн хамгийн эрт үед холбогдох Улаанзуух хэлбэрийн чулуун байгууламж 29, Дөрвөлжин булш 15-ыг бүртгэснээс гадна энэ 2 төрлийн дурсгалтай цогцолбор болон орших чулуун байгууламж 123-ыг илрүүлэн баримтжуулсан. Тухайлбал, Улаанзуух хэлбэрийн дурсгалын хамт 34, Дөрвөлжин булшны хамт нийт 88 (нэг газар хоёр дөрвөлжин булшны хамт 28, нэг Дөрвөлжин булшны баруун талаас баруун урд зүгт цувран нийт 21, өөр нэг Дөрвөлжин булшны хамт 39) байна.

Эдгээр чулуун байгууламж нь тэгш өнцөгт хэлбэртэй, зүүн урагш хандсан үүдтэй, голдоо

Хүснэгт 1. Хайгуулаар бүртгэгдсэн дурсгалын товч мэдээлэл

[Батболд, Галдан 2021]

№	Дурсгалын төрөл	Тоо	Он цаг
1	Улаанзуух хэлбэрийн чулуун байгууламж	29	НТӨ II мянган
2	Дөрвөлжин булш	15	НТӨ X-V зуун
3	Хараат хэлбэрийн чулуун байгууламж	123	НТӨ I мянганы эхэн
4	Хадны зураг	11	НТӨ I мянганы эхнээс НТ V зуун
5	Дугуй булш	12	НТ XII-XIV зуун
6	Он цаг тодорхойгүй чулуун байгууламж	23	-
7	Түүвэр олдворт газар (чулуун зэвсэг, ваарны хагархай гэх мэт)	8	НТӨ IV мянганаас НТ XV зуун
	Нийт	220	

ямар нэгэн чулуу байхгүй, хонхоргүй, зарим тохиолдолд байгууламжийн дотор талд аль нэг буланд нь 3-4 чулуу өрсөн байх нь тохиолдоно. Нэг эгнээнд зэрэгцүүлэн үйлдсэн байх ба заримдаа хоёр гурван эгнээ болгон хийсэн нь бий.

Бударын чулуунаас илэрсэн чулуун байгууламжууд хэмжээний хувьд харилцан адилгүй, хамгийн том нь 6.3x5.0 м, бусад нь дунджаар 4.2x3.0 м хэмжээтэй байх боловч бүтцийн хувьд бүгд ижил байна.

Чулуун байгууламжууд ихэвчлэн Дөрвөлжин булштай хамт, нэг тохиолдолд Дөрвөлжин булш, зосон зургийн хамт нэг дор цогцолбор болон оршиж байна. Тухайн газарт хүн, адуу, олон тооны цэг бүхий зосон зургийн дурсгалтай хамт хоёр дөрвөлжин булш байх ба тэдгээрийн зүүн талд уртрагийн дагуу байрласан гонзгой дөрвөлжин хэлбэртэй, урд талдаа үүд маягийн тасархайтай чулуун байгууламж 28 байна (Зураг 1).

### Зосон зураг.

Бударын чулууны төв хэсэгт орших том өндөр, үргэлжилсэн хадны урагш харсан нөмөр хэсгийн голын эгц толигор хаданд гурван хэсэг газар зосон зураг бий. Энэхүү зосон зургийг анх Сүхбаатар аймгийн Соёл урлагийн газар, угсаатны музейн хамтарсан судалгааны баг олж илрүүлсэн байдаг. Зосон зурагтай хэсгийн баруун захад дотроо олон жижиг тэгш өнцөгт бүхий гонзгой дөрвөлжин, түүнийн зүүн талд буюу хадны зурагтай хэсгийн төвд эгнэсэн олон богиновтор босоо зураасан цэгүүд, доод талд нь морь хөтөлсөн хүн, хажууд нь босоо зам мэт дүрслэл, зүүн захад мөн морьд, хажууд нь хүний тоймлосон дүрс, хамгийн зүүн захад дээд талд нь урдаа олон цэгтэй 2 морь, түүний доод талд мөн урд талдаа олон цэгтэй, хүний тоймлосон зураг зэрэг дүрслэлүүдтэй (Зураг 2-4).

Эдгээр дүрслэлүүд нь “Сэлэнгийн” хэмээн нэрлэгддэг зосон зурагтай ижил өгүүлэмжийг илэрхийлж байна. “Сэлэнгийн” хэмээн нэршсэн хадны зосон зураг төв Монгол, Өвөр Байгалын өмнөд хэсгээр ихэвчлэн тархсан байх ба гол шинж нь дөрвөлжин болон дугуй хүрээ, түүн дотор олон тооны цэг, хүрээний дээд талд далавчаа дэлгэсэн шувуу, хүрээний доор эсвэл хажууд хос зураасны хоёр талд адуу хөтөлсөн хүн, нохой зэргийг дүрсэлсэн байдаг.

Энэ төрлийн хадны зосон зургийн бэлгэдэл, утга зүйн талаар судлаачид “...мал сүрэг улам өсөн нэмэгдээсэй гэсэн овог аймгийнхны хүсэл эрмэлзэл...” [Дорж 2007: 19], [Сэр-Оджав 1977: 43], “...хүрээгээр аймаг буюу овгийг, түүний дотор байрлуулсан цэг нь энэ овгийн гишүүдийг бэлэгдсэн бололтой...” [Окладников 1964: 83], “... хашлага хүрээ татсан ба түүний дотор олон цэгийн

хамт хэд хэдэн хүнийг эгнүүлж дүрсэлсэн буй нь хамтарч тариагаа боловсруулж буй буюу эсхүл газар тариалангийн холбогдолтой баяр ёслолыг тусгасан байж болох...” [Цэвээндорж 1999: 33], “...эртний хүмүүсийн оршуулгын зан үйлтэй...” [Амартүвшин 2002: 16-19], “...эртний хүмүүсийн оюуны соёл дахь ертөнцийн үүсэл гарлын тухай ойлголт дахь... нанайн ертөнцийн модтой” [Батсайхан 2003: 35] холбон үзсэн зэрэг цөөнгүй санал дэвшүүлэн тавьжээ. Эдгээр янз бүрийн тайлбар дундаас хүрлийн үеийн оршуулгын зан үйл гүйцэтгэж байгаа буюу түүнтэй холбоотой үйл явдлыг харуулсан хэмээн үзсэн нь бидний саналтай нийцэж байгаа юм. Ийм зосон зурагтай төстэй сийлмэл зургууд дөрвөлжин булшны ойр орчмоос олддог, мөн дөрвөлжин булшны хана, эсвэл таг чулуун дээр зурагдсан байдаг. Монгол нутаг дахь ийм төрлийн хадны зосон болон сийлмэл зургуудын байрлалыг дөрвөлжин булшны тархалттай харьцуулж үзэхэд тохирч байгаа нь ийм зургууд дөрвөлжин булшны соёлыг үлдээгчидтэй холбоотой гэдэг нь харагдаж байна [Батболд 2014: 66].

Бударын чулууны зосон зураг дөрвөлжин булшны дэргэд оршиж байгаа нь үүний нэг илрэл хэмээн үзэж болохоор байна. Бударын чулууны хадны зураг нь шувуу, дөрвөлжин болон дугуй хүрээ байхгүй боловч олон тооны богиновтор босоо зураасан цэгүүдтэй, түүний ойр орчимд адуу болон хүний дүрслэлтэй, зам мэт босоо зураастай, түүний дэргэд морь хөтөлсөн хүн зэргээрээ “Сэлэнгийн” хэмээх хадны зурагтай ижилсэх ажээ. Энэ нь Монголын зүүн бүс нутаг дахь хадны зургийн онцлог болон он цагийн ялгааг илэрхийлж байж болох юм.

### Хэлэлцүүлэг

“Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд бид хадны зосон зургийн дурсгал шинээр олсон тухай мэдээг шалгах үүднээс Сүхбаатар аймгийн Онгон сумын Бударын чулууны дурсгалт газарт очин ажилласан. Уг зосон зургийг бүртгэн баримтжуулах явцад хадны зосон зургийн дурсгалт газрын хажууд урьд өмнө төдий л олон тохиолдож байгаагүй чулуун байгууламж дөрвөлжин булштай хамт цогцолбор болон оршиж байв. Энэ чулуун байгууламж нь дээр өгүүлсэнчлэн тэгш өнцөгт хэлбэртэй, зүүн урагш 150о (±10о) чиглэлтэй үүдтэй, голдоо ямар нэг чулуугүй, хонхор байхгүй, хэмжээний хувьд том, жижиг харилцан адилгүй боловч бүтцийн хувьд ижил байх бөгөөд энэхүү чулуун байгууламжийг Бударын чулууны дурсгалт газраас одоогоор 123-ыг илрүүлэн бүртгээд байна [Батболд, Галдан 2020].

Ийм төрлийн дурсгал энэ бүс нутгаас анх олдож буй хэрэг биш бөгөөд анх 2016 онд Монгол-Америкийн хамтарсан “Дорнод Монгол” төслийн багийнхан Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Хараат ууланд илрүүлэн тэмдэглэж дэвсгэр зургийг хийсэн байдаг [Амартүвшин нар 2016]. Мөн тухайн жилдээ тус төслийн багийн хайгуулын ангийнхан Дэлгэрхаан уулын Булшит хэмээх газраас бас олж илрүүлэн бүртгэсэн байна [мөн тэнд].

2017 онд “Дорнод Монгол” төслийн баг тухайн дурсгалын он цагийг тогтоох зорилгоор Булшит болон Өлөнгийн голын Улаанзуух хэлбэрийн булш бүхий цогцолбор дурсгалт газарт буй чулуун байгууламжийг сонгон малтлага судалгаа хийсэн (Зураг 5) боловч ямар нэгэн оршуулга, зан үйл үйлдсэн ул мөр болон он цаг тогтоох хэрэглэгдэхүүн илрээгүй ажээ [Амартүвшин нар 2017]. Гэвч судлаачид бидний хэлэлцүүлэн буй чулуун байгууламжийг Улаанзуух хэлбэрийн дурсгалын нэгдүгээр төрлийн дагуул байгууламж хэмээн үзсэн [Wright et al 2019; Хатанбаатар 2019: 62] байна. Уг чулуун байгууламж нь дээрх 2 дурсгалт газарт Улаанзуух хэлбэрийн дурсгалтай цогцолбор болон хамт оршиж буй учраас судлаачид ийн үзсэн бололтой. Улаанзуух хэлбэрийн дурсгалын он цаг энэ бүс нутагт одоогоос 3500-3100 жилийн (НТӨ 1500-1100 он) [Wright et al 2019] хооронд хэлбэлздэг байна.

Харин Бударын чулуунаас илэрсэн чулуун байгууламжууд ихэвчлэн Дөрвөлжин булштай хамт, нэг тохиолдолд Дөрвөлжин булш болон зосон зургийн хамт нэг дор цогцолбор болон оршиж байгаа нь ихээхэн сонирхолтой юм.

Иймд бид уг чулуун байгууламжийн тухайд өмнөх дэвшүүлсэн он цагийн таамгийг эргэн харах, дурсгалын нэршил болон зориулалтын тухай өөрсдийн саналыг дэвшүүлж байна.

Нэгдүгээрт, Дэлгэрхаан уулнаас илэрч олдсон чулуун байгууламжийн хувьд Улаанзуух хэлбэрийн дурсгалын нэг хэсэг болон оршиж буй мэт боловч зарим зүйлийг эргэн санахад илүүдэхгүй билээ. Энэ нь Монголын өндөрлөгт оршин байсан эртний нүүдэлчид өмнөх үеийнхээ үлдээсэн чулуун байгууламжит дурсгалд нэмэлтээр чулуун байгууламж байгуулсан тохиолдлыг тоочоод барахгүй юм. Хамгийн ойрын жишээг дурдахад Дэлгэрхаан уулын Адагийн голд хийсэн судалгаагаар гинжилсэн байдалтай орших Улаанзуух хэлбэрийн дурсгалуудын дунд чулуун байгууламжийг нь эвдэн дараас чулууг ашиглан дөрвөлжин булш байгуулсан тохиолдол бий [Амартүвшин нар 2019]. Мөн дараас чулууг нь ашиглан хиргисүүрийн хүрэн дотор дараа үеийн нүүдэлчид өөрсдийн булш, тахилгын байгууламжаа үйлдсэн тохиолдлууд олон байдаг.

Үүнээс гадна Бударын чулууны дурсгалт газраас 2020, 2021 онд шинээр бүртгэгдсэн чулуун байгууламжууд өмнө нь дэвшүүлсэн он цагийн таамаг буюу Улаанзуух хэлбэрийн булшны дагуул байгууламж гэсэн саналыг [Wright 2019] эргэн харахад хүргэсэн юм. Тодруулбал, Бударын чулууны дурсгалт газар тэмдэглэгдсэн 4 тохиолдлын 3 нь дөрвөлжин булшны хамт, 1 тохиолдол нь Улаанзуух хэлбэрийн дурсгалын хожуу шатанд (одоогоос 3000 орчим жил) хамаарч болзошгүй зөвхөн зүүн талдаа давхар хашлагатай дурсгалын хамт байна. Энэ нь тухайн дурсгалууд Улаанзуух хэлбэрийн дурсгалын төгсгөл үеэс Дөрвөлжин булшны соёлын он цагт холбогдох боломжтойг харуулна. Иймд энэхүү дурсгалыг Улаанзуух хэлбэрийн дурсгалын дагуул байгууламж биш хэмээн үзэхийн зэрэгцээ он цагийг НТӨ II мянганы төгсгөлөөс I мянганы дунд үе хүртэлх хугацаанд хамааруулах саналтай байна.

Хоёрдугаарт, уг тэгш өнцөгт хэлбэрийн чулуун байгууламж цаашид олон бүртгэгдэх төлөвтэй байгаа тул нэршлийн тогтсон хувилбартай болох шаардлагатай хэмээн үзэж байна. Эдгээр чулуун байгууламжийг газрын хөрсөн дээр чулуу өрж болон бага зэрэг суулган байгуулж байсан бөгөөд энэ нь газрын өнгөн хөрс хурдан бүрэлдэн тогтдог бороо чийг сайтай, ургамлын бүрхэвч хөрсжилт ихтэй газруудад ил мэдэгдэхгүй болтлоо булагдсан байх магадлалтай юм. Мөн он цаг тодорхойгүй болон бусад чулуун байгууламж хэмээн судалгааны тайлангуудад дурдагддаг дурсгалуудыг нягтлан үзвэл энэ төрлийн чулуун байгууламжууд нэмэгдэх боломжтой. Улмаар Монгол орны төвийн бүсийн зарим хиргисүүр, дөрвөлжин булшны дэргэд тэдний дагуул тахилын байгууламж бололтой тэгш өнцөгт хэлбэрийн чулуун байгууламж [Очир 2021: 20-21] байдгийг лавшруулан судлууштай юм. Одоогоор бидний хэлэлцүүлэн буй чулуун байгууламжийг Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын Булшит, Өлөнгийн гол [Амартүвшин нар 2017], Онгон сумын Бударын чулуу [Батболд, Галдан 2020] зэрэг газарт бүртгэн баримтжуулсан байгаа хэдий ч анх Мөнххаан сумын Хараат уулнаас илэрсэн (одоогоор хараахан хэвлэгдээгүй байгаа), тухайн газарт анхны дэвсгэр зураг хийгдсэн, нэг бүрчлэн тоолж нарийн бүртгэл хийгээгүй боловч олон тоотой байсанд үндэслэн “Хараат” хэлбэрийн чулуун байгууламж хэмээн нэрлэх саналтай байна. Учир нь шинэ төрлийн дурсгалд нэр өгөхөд анхдагчийн зарчмыг баримтлах [Төрбат 2015: 17] болон анх тэмдэглэгдсэн орон нутгийн нэрийг өгөх [Renfrew, Bahn 1991] зэрэг шаардлагыг хангаж байна хэмээн үзэж байна.

Гуравдугаарт, тус “Хараат” хэлбэрийн чулуун

байгууламжийг Дөрвөлжин булшны соёлын цаг хугацаанд хамааруулах нэг үндэслэл нь тухайн дурсгалын дэргэд орших хадны зосон зураг юм. Хэдийгээр Бударын чулууны хадны зураг нь шувуу, дөрвөлжин болон дугуй хүрээ байхгүй боловч зургийн зохиомжид олон тооны богиновтор босоо зураасан цэгүүд, адуу, хүн, зам мэт босоо зураас, морь хөтөлсөн хүн байгаа зэргээрээ “Сэлэнгийн” хэмээх хадны зурагтай ижилсэх ажээ. Энэ зураг гадуураа ямар нэг хүрээгүй байгаа нь магадгүй Дөрвөлжин булшны соёлын эхэн үед оршуулгын зан үйлд холбогдох зосон зургийг хүрээгүй цэгүүдээр тухайн нас барагчийг төлөөлүүлэн зурдаг байснаа цаг хугацааны явцад оршуулгын зан үйл баяжин өөрчлөгдснөөр зургийн гадна талаар хүрээ зурдаг болсон бололтой. Энэ нь Дөрвөлжин булшны соёлынхон нас барагчдаа эхлээд ямар нэг чулуун хүрэн дотор биш газарт шууд ил тавьдаг байснаа аажмаар ил тавьж буй талийгаачийг тусгайлан бэлдэж зассан хүрэн дотор оруулдаг болсонтой холбоотой байж болохыг харуулна. “Сэлэнгийн” хэмээн нэрлэгддэг зосон зургийг “оршуулгын зан үйлийг харуулсан...” [Амартүвшин 2002: 16-19] гэсэн саналыг бид дэмжихийн сацуу Бударын чулууны хадны зосон зургийн зэргэлдээ байгаа тэгш өнцөгт хэлбэртэй ямар нэгэн оршуулгын нүх зэрэг оршуулгын баримтгүй чулуун байгууламжийг магадгүй талийгчийг ил тавих оршуулгын өвөрмөц зан үйлийн нэг хэлбэр байж болох юм гэсэн саналыг дэвшүүлж байна. Учир нь дээр өгүүлсэнчлэн Хараат төрлийн чулуун байгууламжид ямар нэгэн оршуулга, зан үйл хийсэн ул мөр болон аливаа зүйл шатаасан зэрэг баримт байхгүй хэдий ч чулуун байгууламжийн дотор талд тахилын ширээ маягийн чулуун өрлөг тэмдэглэгдсэн дурсгалт газар бүрт байгаа нь энэ саналыг дэвшүүлэхэд түлхэц боллоо. Мөн чулуун байгууламж бүрийн зүүн урд талд хүн орох зориулалттай үүд бололтой 2 чулуу зоосон байдгийг түүгээр талийгаачийг хүндэтгэлтэйгээр оруулан ил тавьдаг байсан байх гэсэн бидний саналыг батлах баримт хэмээн үзэж байна.

Чулуун байгууламжуудад тавьсан хүнийг ихэвчлэн нэгэн цогцолбор болон орших дөрвөлжин булш руу толгойгоор нь хандуулсан чиглэлтэй тавьдаг байсан бололтой, урт талаараа бүгд дөрвөлжин булш руу буюу хойд зүгт чиглэсэн байх ажээ. Энэ нь өндөр угсаа гарвалтай нийгмийн дээд давхаргын хүмүүсийг нүх ухаж том том хавтгай чулууг хавиргалан зоосон булшинд оршуулж бусад шадар хүмүүсийг тухайн булш руу хандуулан ил тавьдаг байсан бололтой.

Эцэст нь дүгнэхэд, “Хараат” хэлбэрийн чулуун байгууламж нь НТӨ II мянган жилийн төгсгөлөөс I мянганы дунд үе хүртэл буюу Улаанзуух

хэлбэрийн дурсгалын төгсгөл үеэс Дөрвөлжин булшны соёлын он цагийн хүрээнд холбогдох нас барагчаа ил тавьдаг оршуулгын зан үйлийг илтгэн харуулах дурсгал хэмээн үзэж болохоор байна.

### Талархал

Энэхүү өгүүллийн гол судалгааны хэрэглэгдэхүүнийг анх илрүүлэн тэмдэглэж баримтжуулалт хийн бидэнд мэдээлэл өгсөн Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн М.Мандах, Боловсрол, Соёл урлагийн газрын ахлах мэргэжилтэн Б.Золхүү, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн П.Ариунболд, хэрийн судалгааны багийн АЗТГ-ын жолооч н.Бямбаа нарт талархаснаа илэрхийлье.

### Ном зүй

**Амартүвшин 2002** – Ч.Амартүвшин. “Сэлэнгийн” зосон зургийн дүрслэл оршуулгын зан үйлтэй холбогдох нь. - Түүхийн сэтгүүл. УБИС-ийн Түүхийн салбарын Эрдэм шинжилгээний бичиг. Т.Ш, Fasc. 2. Улаанбаатар. 2002. Тал 16-19.

**Амартүвшин 2004** – Ч.Амартүвшин. Археологийн хайгуул судалгааны арга зүйг боловсронгуй болгох нь. - Докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, 2004.

**Амартүвшин нар 2015** – Ч.Амартүвшин, З.Батсайхан, Г.Галдан, Б.Батдалай, У.Ханичёрч, Ж.Врайт. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан ууланд ажилласан “Дорнод Монгол” археологийн хайгуул судалгааны ангийн 2015 оны тайлан. - ШУА, АХНС, Улаанбаатар.

**Амартүвшин нар 2016** – Ч.Амартүвшин, З.Батсайхан, У.Эрдэнэбат, Г.Галдан, Б.Батдалай, У.Ханичёрч, Ж.Врайт, С.Плугер. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан ууланд ажилласан “Дорнод Монгол” археологийн хайгуул судалгааны ангийн 2016 оны тайлан. - ШУА, АХНС, Улаанбаатар.

**Амартүвшин нар 2017** – Ч.Амартүвшин, З.Батсайхан, У.Эрдэнэбат, Б.Бадма-Оюу, Г.Галдан, Б.Батдалай, Д.Мандах, У.Ханичёрч, Ж.Врайт, С.Плугер. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан ууланд ажилласан “Дорнод Монгол” археологийн хайгуул судалгааны ангийн 2017 оны тайлан. - ШУА, АХНС, Улаанбаатар.

**Амартүвшин нар 2018** - Ч.Амартүвшин, З.Батсайхан, У.Эрдэнэбат, Г.Галдан, Б.Батдалай, Д.Мандах, У.Ханичёрч, Ж.Врайт, С.Плугер. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан ууланд ажилласан “Дорнод Монгол” археологийн хайгуул судалгааны ангийн 2018 оны тайлан. - ШУА, АХНС, Улаанбаатар, 2018.

**Амартүвшин нар 2019** – Ч.Амартүвшин, З.Батсайхан, У.Эрдэнэбат, Г.Галдан, Б.Батдалай,

Д.Мандах, У.Ханичёрч, Ж.Врайт, С.Плугер. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан ууланд ажилласан “Дорнод Монгол” археологийн хайгуул судалгааны ангийн 2019 оны тайлан. - ШУА, АХНС, Улаанбаатар, 2019.

**Амартүвшин 2020** - Ч.Амартүвшин. Түрүүлгэ нь харуулсан оршуулгат булш. - Монголчуудын гарал, угсаа соёлын хөгжил. Улаанбаатар. х 22-51.

**Батболд 2014** – Н.Батболд. Хадны зураг дахь оршуулгын зан үйлтэй холбогдох өвөрмөц дүрслэлийн тухай. - Хүрэл, түрүү төмрийн үе ба Хүннүгийн өмнөх соёлын судалгааны асуудал. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Улаанбаатар, 2014. Тал 64-70.

**Батболд, Галдан 2020** – Н.Батболд, Г.Галдан. “Хадны зургийн шинэ судалгаа (чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд Дорноговь, Сүхбаатар аймгийн нутагт хийсэн хадны зургийн судалгааны 2020 оны тайлан. //ШУА, АХНС. Улаанбаатар.

**Батболд, Галдан 2021** – Н.Батболд, Г.Галдан. “Хадны зургийн шинэ судалгаа (чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд Сүхбаатар аймгийн нутагт хийсэн хадны зургийн судалгааны 2021 оны тайлан. - ШУА, АХНС. Улаанбаатар.

**Батсайхан 2003** – З.Батсайхан. “Сэлэнгийн” хэмээх зосон зургуудыг шинээр тайлбарлах нь. - Археологи, антропологи, угсаатан судлал. МУИС-ийн НШУС-ийн эрдэм шинжилгээний бичиг. № 210(19). - Улаанбаатар. Тал 34-39.

**Бөхчулуун нар., 2020** – Д.Бөхчулуун, Э.Камерон, Д.Одсүрэн, М.Алтаншагай, А.Орхонсэлэнгэ, Д.Волин, К.Корралуус. Монгол-Америкийн хамтарсан “Говийн бүс нутгийн археологийн судалгаа” төслийн 2019 оны хээрийн судалгааны тайлан. – ШУА-ийн АХГБСХ. - Улаанбаатар.

**Галдан 2010** – Г.Галдан. Бага Газрын Чулуунд хийсэн хадны зургийн судалгаа. – Магистрын дипломын ажил. МУИС-ийн Археологи-Антропологийн тэнхим. Улаанбаатар. тал 10-14.

**Галдан, Дайсүкэ 2023** – Г.Галдан, Н.Дайсүкэ. (2023). Археологийн дурсгалын нэрийн гажуудал: Дорнод Монголын хүрэл ба түрүү төмөр зэвсгийн үеийн археологийн дурсгалын жишээн дээр. – *Studia Archaeologica*. Tom. XLII, fasc 10. Улаанбаатар. Т-108-114. <https://doi.org/10.5564/sa.v42i1.2823>

**Дорж 2007** – Д.Дорж. Монголын хүрлийн үеийн хадны зураг. - Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. - Улаанбаатар.

**Окладников 1964** – А.П.Окладников. Олень Золотые Рога. - Ленинград. стр 83.

**Очир 2021** – А.Очир. Монголчуудын гарал. - Түүхийн судлал. Т.Л, fasc. 1, Улаанбаатар, 2021.

тал 09-52.

**Төрбат 2015** – Ц.Төрбат. Монгол Алтайн хүрлийн үеийн судалгааны тулгамдсан асуудлууд. – Хүрэл, түрүү төмрийн үе ба Хүннүгийн өмнөх соёлын судалгааны асуудал. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. – Улаанбаатар.

**Хатанбаатар 2019** – Д.Хатанбаатар. Монгол нутаг дахь хүрлийн үеийн түрүүлгэ харуулсан оршуулгат булшны судалгааны зарим асуудалд. – Түүхийн ухаанаар доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар. Тал 62.

**Сэр-Оджав 1977** - Н.Сэр-Оджав. Монголын эртний түүх. - Улаанбаатар. тал 43.

**Цогтбаатар, Гэрэлбадрах 1997** – Б.Цогтбаатар, Ж.Гэрэлбадрах. Бударын чулууны хадны зураг. – *Studia Archaeologica*. Tom. XVII, fasc. 5, - Улаанбаатар. тал 66-72.

**Цэвээндорж 1999** – Д.Цэвээндорж. Монголын эртний урлагийн түүх. Улаанбаатар. тал 33.

**Honeychurch 2015** - Honeychurch W. Inner Asia and the spatial politics of empire: archaeology, mobility, and culture contact. Springer, New York.

**Rawson et al 2020** - Rawson J., Chugunov K., Grebnev Y., Huan L. Chariotry and Prone Burials: Reassessing Late Shang China's Relationship with Its Northern Neighbours. *J World Prehist* 33, 135–168. <https://doi.org/10.1007/s10963-020-09142-4>

**Renfrew, Bahn 1991** – Renfrew C., Bahn P. Archaeology: Theories, Methods, and Practice. – New York. pp-63.

**Taylor et al 2019** – Taylor W., Wilkin S., Wright J., Dee M., Erdene M., Clark J., Tuvshinjargal T., Bayarsaikhan J., Fitzhugh W., Boivin N. Radiocarbon dating and cultural dynamics across Mongolia's early pastoral transition. – *Plos one* 14 (11). Research article.

**Wright et al 2019** – Wright J., Galdan G., Honeychurch W., Batdalai B., Arlene Rosen. The earliest Bronze Age Culture of the south-eastern Gobi Desert, Mongolia. - *Antiquity Publications Ltd*. <https://doi.org/10.15184/aqy.2018.174>


Өгүүлэл хүлээн авсан: 2023 оны 09 сарын 30

Өгүүлэл засварласан: 2023 оны 11 сарын 17


Өгүүлэл хэвлэгдсэн: 2023 оны 12 сарын 01



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.




Зураг 1. Хараат хэлбэрийн чулуун байгууламжийн харагдах байдал ©Г.Галдан  
(Сүхбаатар аймаг Онгон сум, Бударын чулууны дурсгалт газар)




Зураг 2. Бударын чулууны хадны зосон зургийн нэгдүгээр зохиомж






Зураг 3. Бударын чулууны хадны зосон зургийн хоёрдугаар зохиомж



Зураг 4. Бударын чулууны хадны зосон зургийн гуравдугаар зохиомж



Зураг 5. Хараат хэлбэрийн чулуун байгууламжийн харагдах байдал ©Б.Батдалай  
(Сүхбаатар аймаг Түвшинишрээ сум, Булиштын дурсгалт газар)



Зураг 6. Хараат хэлбэрийн чулуун байгууламжид хийсэн малтлага судалгаа  
(Сүхбаатар аймаг Түвшинишрээ сум, Булиит болон Өлөнгийн голын дурсгал)  
©Б.Батдалай